



ОХУ-ын Засгийн Газрын тэтгэлэгээр Оросын Холбооны Улсад суралцуулах зорилгоор гадаадын иргэн, иргэншилгүй хүмүүс болон гадаадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн дунд сонгон шалгаруулалтыг явуулах журам

Бакалавр, мэргэжил зэрэг хөтөлбөрийн дагуу элсэж буй горилогчдын дунд явуулах сонгон шалгаруулалтын журам

Бакалавр, мэргэжил гэсэн хөтөлбөрөөр элсэж буй горилогчдын сонголтыг өмнөх боловсролын үнэлгээ болон түүний гаргасан хувийн амжилтын нийлбэр оноог тооцох үндсэн дээр хийнэ.

Бакалавр, мэргэжил гэсэн хөтөлбөрөөр элсэж буй горилогчдын өмнөх боловсролын үнэлгээний тооцоо

Бакалавр, мэргэжил гэсэн хөтөлбөрөөр элсэж буй горилогчдын өмнөх боловсролын үнэлгээний тооцоо нь дараах томъёонуудын дагуу 0,01 нарийвчлалтай гарна:

- боловсролын үнэмлэхэд байгаа хичээлүүдийн дундаж оноо $C = A / B$,
энд A -бүх хичээлийн нийлбэр оноо,
 B - хичээлийн нийт тоо ;

- Эцсийн үзүүлэлт $F = (C + D_1 + D_2) / 3$,
энд C – боловсролын үнэмлэхэд байгаа хичээлүүдийн дундаж оноо,
 D_1 ба D_2 – Журмын 1.2. Хавсралтын дагуу тогтоосон голлох 1 ба 2-р хичээлийн оноо.

Шаардлагатай голлох хичээлийн дүн байхгүй бол голлох нэг хичээлийн оноог тооцож нийлбэрийг 2-т хуваана.



Хувийн амжилтын онооны тооцоо

Хувийн амжилтын онооны тооцоо (бакалавр, мэргэжил)-г хийхдээ «Тэтгэлээр суралцуулах сонгон шалгаруулалтын явцад зохих хөнгөлөлт олгох арга хэмжээ» гэсэн зүйлийг баримтлана.

Магистр, аспирантур, ординатур зэрэг хөтөлбөрийн дагуу элсэж буй горилогчдын дунд явуулах сонгон шалгаруулалтын журам

Магистр, аспирантур, ординатур зэрэг хөтөлбөрийн дагуу элсэж буй горилогчид тестын шалгалтанд орохгүй. Сонголтыг өмнөх боловсролын үнэлгээ болон хувийн амжилтын нийлбэр оноог тооцох үндсэн дээр хийнэ.

Магистр, аспирантур, ординатурын хөтөлбөрөөр элсэж буй горилогчдын өмнөх боловсролын үнэлгээний тооцоо

магистр, аспирантур, ординатур гэсэн хөтөлбөрөөр элсэж буй горилогчдын өмнөх боловсролын үнэлгээний тооцоо нь дараах томъёонуудын дагуу 0,01 нарийвчлалтай гарна:

- боловсролын үнэмлэхэд байгаа хичээлүүдийн дундаж оноо $C = A / B$,
энд A -бүх хичээлийн нийлбэр оноо,
 B - хичээлийн нийт тоо.

Хувийн амжилтын онооны тооцоо

Магистрын хөтөлбөрөөр элсэж байга горилогчдын хувийн амжилтын оноог дараах үзүүлэлтээр тооцно:

- 5 оноо - горилогчийн юуны түрүүнд орох хүсэлтэй их дээд сургуулиас ирүүлсэн дэмжлэг хүссэн тухай албан тоот байвал. Гэхдээ албан тоотыг тус сургуулийн захирал эсвэл дэд захирлын гарын үсгээр баталгаажуулсан байна;



- 5 оноо хүртэл – Ажлын хэсгийн хүрээнд биечлэн буюу зайны технологийг ашиглан явуулсан онлайн ярилцлагыг үндэслэн;
- 5 оноо боловсролын эрдэм шинжилгээний бага хурал, симпозиумд оролцсон бол;
- 5 оноо - эрдэм шинжилгээний нийтлэл гаргасан бол, гэхдээ номын жагсалтын хамт ;
- 5 оноо – өмнөх боловсролыг “онц сайн” дүнтэй хэмээн нотолсон баримт бичиг байгаа бол (тухайн оронд ийм дадал туршлага үгүй бол өмнөх боловсролын баримт бичигт тухайн оронд байж болох хамгийн өндөр онооны 95 %-аас доошгүй сургалттайг нотолсон баримт байвал);
- 5 оноо – сошиал төсөлд оролцсон бол (жишээлбэл сайн дурынхны хөдөлгөөн гэх мэт);
- 1 б оноо спортод гаргасан амжилт байвал;
- 1 оноо урлагт гаргасан амжилт байвал.

Эцсийн онооны тоо дээрх үзүүлэлтүүд бүрт ногдох онооны нийлбэртэй тэнцэнэ.

Аспирантур, ординатурын хөтөлбөрөөр элсэж байгаа горилгочдын оноог доорх үзүүлэлт бүрээр авсан онооны нийлбэрээр тооцно:

- 15 оноо горилогчийн юуны түрүүнд сурах хүсэлтэй их дээд сургуулиас ирүүлсэн дэмжлэг хүссэн тухай албан тоот байвал, гэхдээ урьдчилсан байдлаар томилсон аспирант буюу ординаторын эрдэм шинжилгээний удирдагчийн овог нэрийг бичсэн байна. Мөн албан тоотыг тус сургуулийн захирал эсвэл дэд захирлын гарын үсгээр баталгаажуулсан байна;
- 1 оноо нийтлэл бүрт ногдуулна (тооцох хамгийн олон нийтлэлийн тоо-5, энэ үзүүлэлтийн хамгийн их оноо-5 байна);
- 5 оноо хүртэл Ажлын хэсгийн хүрээнд биечлэн буюу зайны технологийг ашиглан явуулсан онлайн ярилцлагыг үндэслэн;
- Эцсийн онооны тоо дээрх үзүүлэлтүүд бүрт ногдох онооны нийлбэртэй тэнцэнэ.



Тэтгэлэгээр суралцах сонгон шалгаруулалтад хөнгөлөлт ногдуулах арга хэмжээнүүд

Хүснэгт 1. Горилогчдыг шалгаруулах нэгдүгээр шатанд тооцох олимпиадын жагсаалт, которые засчитываются в качестве первого этапа отбора кандидатов на квоту (тооцоонд сүүлийн 3 жилд үзүүлсэн амжилт орно, гэхдээ ялагчийн ба шагналт байрны медаль эсвэл диплом байх шаардлагатай).

№	Олимпиадын нэр оросоор	Название Олимпиадын нэр англиар
1	Олон улсын идэрчүүдийн байгалийн ухааны олимпиад (МЕО)	International Junior Science Olympiad (IJSO)
2	Олон улсын математикийн олимпиад (ММО)	International Mathematical Olympiad (IMO)
3	Олон улсын физикийн олимпиад (МФО)	International Physics Olympiad (IphO)
4	Олон улсын биологийн олимпиад (МБО)	International Biology Olympiad (IBO)
5	Олон улсын химийн олимпиад (МХО)	International Chemistry Olympiad (IChO)
6	Олон улсын информатикийн олимпиад (МОИ)	International Olympiad in Informatics (IOI)
7	Олон улсын астрономи, астрофизикийн олимпиад (МОАА)	Olympiad on Astronomy and Astrophysics (IOAA)
8	Олон улсын астрономийн олимпиад (МАО)	International Astronomy Olympiad (IAO)
9.	Олон улсын «Open Doors» олимпиад	Open Doors Olympiad
10.	ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яамны тушаалаар батлагдсан сурагчдын олимпиадын жагсалтад орсон 1 ба 2-р түвшний олон улсын олимпиадууд: (байгалийн ухааны <u>олимпиадууд</u> : эдгээр олимпиадын дүнгээр зөвхөн мэдүүлэгдээ Хавсралт 1.2 тусгасан №1,2,3,4,6 хэсэгт	International Olympiads of the I and II level, included in the list approved by the order of the Ministry of education



<p>багтах мэргэжлээр суралцах хүсэлтээ ирүүлсэн горилогчдод оноо тооцно</p> <p>Хүмүүнлэгийн олимпиадын хувьд; эдгээр олимпиадын дүнгээр зөвхөн мэдүүлэгдээ Хавсралт 1.2 тусгасан №5,6-р хэсэгт багтах мэргэжлээр суралцах хүсэлтээ ирүүлсэн горилогчдод оноо тооцно</p> <p>* өмнөх боловсролын баримт бичигт тухайн хичээлийн үзүүлэлт 75 %-иас доошгүй байвал.</p>	
---	--

Хүснэгт 2. Хувийн амжилт (цаашид ХА гэх)-нд нэмэлт оноо ногдуулах арга хэмжээний Жагсаалт (энд сургуулиа төгсөх буюу төгсөхийн өмнөх оны үзүүлэлтийг тооцно, гэхдээ 2019 оноос өмнө байж болохгүй).

№	Нэр	ХА-ийн оноо
1-р зэрэг		
1	ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яамны тушаалаар батлагдсан сурагчдын олимпиадын жагсалтад орсон 1 ба 2-р түвшний олон улсын олимпиадууд	Ялагч эсвэл шагналт байр бол– 15 оноо * байгалийн ухааны олимпиадын дүнгээр зөвхөн мэдүүлэгдээ Хавсралт 1.2 тусгасан №1,2,3,4,6 хэсэгт багтах мэргэжлээр суралцах хүсэлтээ ирүүлсэн горилогчдод оноо тооцно Хүмүүнлэгийн олимпиадын дүнгээр зөвхөн мэдүүлэгдээ Хавсралт 1.2 тусгасан №5,6-р хэсэгт багтах мэргэжлээр суралцах хүсэлтээ ирүүлсэн горилогчдод оноо тооцно



		* өмнөх боловсролын баримт бичигт тухайн хичээлийн үзүүлэлт 75 %-иас доошгүй байвал
2-р зэрэг		
2	ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яамны тушаалаар батлагдсан сурагчдын олимпиадын жагсалтад орсон 1 ба 3-р түвшний олон улсын олимпиадууд	Ялагч эсвэл шагналт байр бол– 10 оноо*
3	Россотрудничество агентлагийн төлөөлөгчийн газрын тэргүүний мэдэл дор тухайн улс оронд Россотрудничество агентлагийн төв аппараттай зөвшилцөн ОХУ-ын их дээд сургуулиудын зохион явуулах олон улсын олимпиадууд (эсвэл Россотрудничество агентлагийн үүрэг гүйцэгч өөр байгууллага).	* байгалийн ухааны олимпиадын дүнгээр зөвхөн мэдүүлэгдээ Хавсралт 1.2 тусгасан №1,2,3,4,6 хэсэгт багтах мэргэжлээр суралцах хүсэлтээ ирүүлсэн горилогчдод оноо тооцно Хүмүүнлэгийн олимпиадын дүнгээр зөвхөн мэдүүлэгдээ Хавсралт 1.2 тусгасан №5,6-р хэсэгт багтах мэргэжлээр суралцах хүсэлтээ ирүүлсэн горилогчдод оноо тооцно
4	Дээд түвшний сонголттой үндэсний төрөлжсөн олимпиадуудын төгсгөлийн шат. (тухайн улсаас хамаарч– Улсын олимпиад / сурагчдын үндэсний /Бүх украины олимпиад/ Бүх оросын олимпиад)	
3-р зэрэг		
5	Ажлын хэсгийн үзэмжээр бусад хувийн амжилтыг тооцох, гэхдээ заавал биелүүлэх дараах болзолтой: энэхүү амжилтанд хүрэх явдал нь нээлттэй, хүртээлтэй хийгээд үнэ төлбөргүй үндэс дээр хэрэгжих ёстой.	5 оноо хүртэл (бүх амжилтанд оноох хамгийн их оноо)